

2013 оны 5 сараас шинэчлэгдэх гэж буй гадаад иргэдийн оршин суух тухай хуулийн хатуурхал

Оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах, цуцлах 1001 шалтгаан

Гадаадын иргэд (ЕХ-ноос бусад улс орны иргэдэд хамаарах албаны дэндүү чанга хяналтанд орж байна тухайн иргэны амьдралд ямар нэгэн өөрчлөлт гарах бүрт (ажилаа алдах, бизнесээ зогсоох, гэр бүлийн салалт, хичээлийн жил дуусах) оршин суух зөвшөөрлөө алдах болж байна. Дотоод явдалын яамны өмнөх дараалсан урт оочероос болж хүрэх боломжгүй албан хаагчийн тамганаас тэдний амьдрал шалтгаална. Нөгөөтэйгүүр яамны албан хаагчид хуулинд заасан хугацаандаа өргөдлийг шийдвэрлэж амжихгүй. Виз, оршин суух зөвшөөрлөө сунгуулахдаа ямар нэгэн алдаа гаргаж, түвэгтэй байдал үүсгэхгүйн тулд гадны иргэдийг өндөр үнэтэй өмгөөллын товчоо эсвэл мэргэжлийн зуучлагч нарын үйлчилгээнд хандахад хүргэж байна. Хэрвээ ажил эрхлээгүй тохиолдолд нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхгүй, иймээс ихэнх эмчилгээнд үйлчилдэггүй эрүүл мэндийн худалдааны даатгалд даатгуулахаас өөр аргагүй. Гэр бүлийн харилцаа, хурим зэргээ хойшлуулах, албан газарт үзүүлэх ёстой цэвэр орлого гэр бүлийн гишүүн бүрийн тоогоор нэмэгддэг.

- **Тэдний тайван амьдрах ганц боломж нь нь trvaly robyt-тай болох- харамсалтай нь trvaly robyt-д хүрэхэд өмнөхөөсөө илүү түвэгтэй болох нь, учир нь дотоод явдалын яам дараах өөрчлөлтийг санаачилж байна.**
- “үндэсний виз” хэмээх шинэ ойлголт гарч ирж байна. Ийм визийг нь БНЧУ-д түр хугацаагаар оршин суух тохиолдолд олгогдох бөгөөд сунгуулах боломжгүй юм. Эзэмшигч нь хөдөлмөр эрхлэх үедээ нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхгүйгээс гадна хэзээ ч ЧУ-д гэр бүлээ авчирч үлдэх боломжгүй юм байна.
- Бусад гадаад иргэдэд байнгын оршин суух зөвшөөрөл хүсэх, БНЧУ-д гэр бүлээ авчран хамт амьдрах боломж дараах нөхцөлтэй: Гэр бүлийн нэг гишүүнд 15.400 К\$, гэр бүлийн хоёр гишүүнд 22.000 К\$, гэр бүлийн гурав ба түүнээс дээш гишүүнд 28.600 К\$-ы цэвэр орлогын (ямар ч нийгмийн халамж, тэтгэглэгийг тооцохгүйгээр) баталгаа үзүүлэх шаардлагатай. Жишээлбэл оюутны виз хүсэгчийн орлогын хэмжээнд тавигдах шаардлага өндөрсөнө
- Зөвхөн баталгаатай, найдвартай хэрэгжиж болохуйц бизнесийн чиглэлүүд БНЧУ-д ач холбогдол бүхий хөрөнгө оруулалт хийх этгээд бизнес эрхлэх боломжтой. Худалдааны байгууллага (корпораци)-н хувьд тухайн байгууллагын үйл ажиллагаанд гадаадын иргэн үнэхээр үүрэг ач холбогдолтой оролцож буй эсэхийг яам харгалзан үзнэ. Өмнө яамнаас санаачилж байсан байнгын оршин суух зөвшөөрөл хүсэх нөхцөлийг зарим нэгийг нь шинэ хуулийн төслөөр цуцлахаар тооцоолж байна.
- Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулинд оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах /сунгахгүй байх/, цуцлах 20 орчим шалтгаантай байдаг бол шинэ хууль нь 60 орчим ийм шалтгаантай!
- Гадны иргэн ажил олгогчоосоо хамааран оршин суух эрхээ цуцлуулах, шийтгүүлэж болно
- Шинэчлэгдэх гэж буй хуулийн дагуу гадаад иргэн бүрт оршин суух зөвшөөрөл олгох нь тагнуулын албанаас шууд хамаарна. Тухайн гадаадын иргэн улс, ард түмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй талаар нууц мэдээлэл олсон тухай тагнуулын албаны мэдэгдлийг үндэслэн уг гадаадын иргэнд шалтгаан

дурдалгүйгээр зөвшөөрлийг олгохоос татгалзана. Ийм тохиолдолд гадаадын иргэн тагнуулын албанаас ирүүлсэн мэдээлэлтэй танилцах, шийдвэрийг эсэргүүцэж шүүхэд хандах боломжгүй.

- **Чех хүн болж төрөөгүйн төлөө Төр таны амьдралд дарамт үүсгэх эрхтэй гэжүү?**
Эдгээр өөрчлөлтүүд танд таалагдахгүй бол бидэнтэй нэгдээрэй! jednej.cz
- Холбоо барих: office@konsorcium-nno.cz
- Дэлгэрнгүйг www.migraceonline.cz/cz/temata/novy-cizinecky-zakon